



МОНГОЛ АРДЫН ХУВЬСГАЛТ НАМД

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30

2017. 05. 16 № 956

танай _____-ны № _____-т

Дүгнэлт хүргүүлэх тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.18-д заасан бүрэн эрхийн хүрээнд Сонгуулийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5-д заасны дагуу Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгуульд танай намаас нэр дэвшигч Сайнхүүгийн Ганбаатарын сонгуулийн мөрийн хөтөлбөрт аудит хийж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдэгдэл

Монгол Ардын Хувьсгалт нам Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт орсон зорилт, арга хэмжээ нь Төсвийн тогтвортой байдлын тухай, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуульд нийцсэн байдал, мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэрийн талаарх тооцоо, судалгааг үнэн зөв гаргаж, нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг тооцоо судалгаанд үндэслэн, найруулгын хувьд ойлгомжтой, хоёрдмол утгагүйгээр боловсруулан Үндэсний аудитын газарт ирүүлэх үүрэгтэй.

Монгол Ардын Хувьсгалт намаас Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт орсон зорилт, арга хэмжээнүүд нь Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалд нийцсэн эсэх болон мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэрт дүгнэлт өгөх нь Үндэсний аудитын газрын үүрэг юм.

Дүгнэлтийн үндэслэл

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт орсон зорилт, арга хэмжээг хянан үзэхдээ Монгол Улсын Үндсэн хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль, Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолоор батлагдсан "Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030"-ыг, мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэрийн тооцооллыг шалгахдаа Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль болон Монгол Улсын нэгдсэн төсвийн 2017 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2018-2019 оны төсвийн төсөөллийн тухай хуулийг тус тус шалгуур болгон авч үзсэн болно.

Дүгнэлт

Нэг. **Мөрийн хөтөлбөрт орсон зорилт, арга хэмжээ нь Монгол Улсын Хөгжлийн үзэл баримтлалд нийцсэн эсэх талаар**

Энэхүү дүгнэлтэд хавсаргасан Монгол Ардын Хувьсгалт намаас Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгуульд нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт орсон зорилт, арга хэмжээ нь Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалд нийцсэн байна.

000033

070359

Хоёр. Мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэрийн талаар
Энэхүү дүгнэлтэд хавсаргасан Монгол Ардын Хувьсгалт намаас Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгуульд нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт санхүүжилт, эх үүсвэр шаардагдах зорилт, арга хэмжээнүүд тусгагдаагүй тул дүгнэлт гаргаагүй болно.

Хувийг: Сонгуулийн Ерөнхий Хороонд

Хавсралт 6 хуудастай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



Д.ХҮРЭЛБААТАР

000037

**МАХН-аас Монгол Улсын 2017 оны Ерөнхийлөгчийн сонгуульд
нэр дэвшигч Сайнхүүгийн Ганбаатарын
“Их аян эхлэхүй” Мөрийн хөтөлбөр**

*Уриа:
“Монголоо сонгоё”*

Нэгдэх хэсэг. Ам ба ажлын нэгдлийг хангаж, Ажилгүйдэл ба Ядуурлыг арилгахуй

Хоёрдох хэсэг. Шударга ёсыг тогтоохуй

Гуравдах хэсэг. Ард түмний дээд эрх ашгийг эрхэмлэхүй

Дөрөвдэх хэсэг. Монгол хүн болж төрснөөрөө бахархахуй

Тавдахь хэсэг. Монгол хүний үнэлэмжийг дээшлүүлэхүй

Зургаадах хэсэг. Тулгамдсан асуудлыг шийдэж, Амжилтанд хүрэхүй

Долоодох хэсэг. Гурван сайханы эзэн болохуй


Наймдах хэсэг. Үг ба үйл нэгдэхүй

Есдэх хэсэг. Их аян эхлэхүй

ж ж ж

Нэгдэх хэсэг. Ам ба ажлын нэгдлийг хангаж, Ажилгүйдэл ба Ядуурлыг арилгахуй

Нэгэн зүйл. Өнөөдөр Монгол Улсад хамгийн их тулгамдсан асуудал бол намуудын сонгуулийн амлалт ба сонгуулийн дараа авч хэрэгжүүлж байгаа ажил хоёрын хоорондын зөрүү юм. Иргэд амлалт ба ажил хоёр хоорондоо ихээхэн зөрснийг төр засгийн үйл ажиллагаа хариуцлагагүй шинж чанартай



болж байгаагийн илэрхийлэл мөн хэмээн шүүмжилж, энэ байдлыг нэн даруй засан залруулахыг шаардаж байна.

Нэгэн зүйл. Иргэдийн үзэж байгаагаар ард түмний бухимдалыг төрүүлж буй нэгэн гол учир шалтгаан бол ажилгүйдэл мөн. Өнөөгийн төр засаг энэхүү тулгамдсан асуудлыг шуурхай шийдвэрлэж чадахгүй байгаагаас ажилгүйдэл өсөн нэмэгдсээр 10 гаруй хувьтай болжээ. Энэ нь ажилгүйдэл шууд болон шууд бус байдлаар манай нийгэмд бухимдалыг төрүүлж, монголын олон сайхан залуус ажил, орлоготой болохын тулд өөрийн эрхгүй олноороо эх орноосоо дайжин гарч өөр улс орныг зорих байдалд хүрч байна.

Нэгэн зүйл. Улс төр, нийгэм, эдийн засгийн хямралт байдал гүнзгийрэх тусам ард иргэдийн орлого багасч, “Сант Марал” зэрэг судалгааны байгууллагуудын гаргасан судалгаагаар ядуурал хамгийн тулгамдсан асуудлын нэг болжээ. Судалгаанаас үзэхэд ядуу хүн, ядуу гэр бүл наад захын хэрэгцээнийхээ зүйлийг худалдан авахаас цаашгүй, ирээдүйгээ төлөвлөж чадахгүй байдалтай амь зогоож байна. Энэхүү улс төр, нийгэм, эдийн засгийн хямралт байдлаас гарахын тулд юуны түрүүн:

1. *Төр засгийг хариуцлагажуулах,*
2. *Ажилгүйдлийг багасган арилгах,*
3. *Ядуурлыг бууруулан алга болгох*

ажилд бүгд ханцуй шамлан орох шаардлагатай байна.

Хоёрдох хэсэг. Шударга ёсыг тогтоохуй

Нэгэн зүйл. Өнөөдөр иргэд ажилгүйдэл, ядуурлаас шалтгаалан баян, хоосны ялгаа улам бүр өсөн нэмэгдэж, харьцангуй чинээлэг дундаж давхарга улам бүр багасч байгааг шударга ёс алдагдсаны илэрхийлэл мөн хэмээн үзэж, ингэснээр нийгмийн тогтвортой байдал алдагдах нөхцөл байдал бүрджээ. Ялангуяа оффшор дансны асуудал иргэдийн ихээхэн бухимдалыг төрүүлж байна.

Нэгэн зүйл. Иргэд шударга ёс тогтоохыг оффшор дансанд байрлуулсан хөрөнгө мөнгийг буцааж Монголд авчирч нийгэм, эдийн засгийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд зарцуулах, байгалийн баялагаас тэгш хүртэх, дээд сургуульд сурах нөхцлийг сайжруулах, эмчилгээний чанар, хамрах хүрээг

нэмэгдүүлэн өргөжүүлэх, төр засгийн байгууллагуудын хүнд суртлыг арилгах, хууль, шүүхийн байгууллагын явуулж буй үйл ажиллагаа шударга байх явдал мөн хэмээн үзэж байна. Иргэд чухамхүү ийм шударга ёсыг тогтоохын төлөө олноороо жагсаал, цуглаан хийх байдлаар тэмцэл өрнүүлж байгааг төр засаг, албан тушаалтнууд харах, сонсох, ухаарах цаг иржээ. Энэ тэмцлийн цаана Монгол Улсад шударга ёс тогтох эсэх асуудал тавигдаж байгаа учир монгол хүн бүршударга ёсны төлөө дуу хоолойгоо өргөх нь Монголын ард түмний хувь заяаг тэгшитгэх түүхэн ач холбогдолтой үйл хэрэг болно.

Гуравдах хэсэг. Ард түмний дээд эрх ашгийг эрхэмлэхүй

Нэгэн зүйл. Монголчууд бүгдээрээ “Хариуцлагагүйн зуднаас салъя!” хэмээн нийтээрээ зорьж, “Одоо л салахгүй бол оройтоно” гэдгийг зүрх сэтгэлдээ гүн гүнзгий ортол мэдрэн ухаарч байна. Энэхүү зорилгод хүрэх амжилтын үндэс суурь нь намын эрх ашгийг хойш нь харин Монгол хүний эрх ашгийг эн тэргүүнд тавих явдал мөнөөс мөн. Ингэснээр Монгол хүнөөрийнхөө болон гэр бүл, үр хүүхдийнхээ хувь заяанд жинхэнэ эзэн болох юм.


Дөрөвдэх хэсэг. Монгол хүн болж төрснөөрөө бахархахуй

Нэгэн зүйл. Та бид эхээс тус тусдаа төрдөг ч Монгол хэмээх ариун нэрэн дор нэгдэж Монгол хүн болж төрснөөрөө бахархдаг. Монгол хүн эрт дээр үеэс эхлэн шударга ёсыг эрхэмлэж, шударга бусыг үл тэвчдэгээрээ бусдаас ялгарч ирсэн түүхтэй. Та бид үнэхээр Монгол хүн мөн учир өнөөгийн Монгол Улсад ихээхэн ховордсон шударга ёсыг эгүүлэн тогтоох үйл хэрэгт хүчин зүтгэх үүрэгтэй.

Нэгэн зүйл. Шударга ёсонд тогтсон бат бэх эв нэгдэл, бат бэх эв нэгдэлд суурилсан эрчимтэй хөгжлийн бодлого, эрчимтэй хөгжлийн бодлогод тулгуурласан идэвхтэй үйл ажиллагаа, “ам ажлын нэгдэл” Монгол Улсад:

1. Хариуцлагатай төр засгийг

эмхлэн байгуулж,



Төрийн захиргаа
УХА

2. Шударга ёсыг

бат бэх тогтоож,

3. Ажилгүйдлийг

арилгаж,

4. Ядуурлыг

устгана.

Нэгэн зүйл. Ингэснээр монголын залуус Монгол Улсдаа ажлын байраар найдвартай хангагдаж, баталгаатай орлоготой болно. Тэд ажил, орлогын хойноос хөөцөлдөж эх орноосоо дайжин дүрвэх шаардлагагүй болно. Монгол гэр бүл, монголын ард түмэн бүрэн бүтэн байх болно.

Тавдахь хэсэг. Монгол хүний үнэлэмжийг дээшлүүлэхүй

Нэгэн зүйл. Улс төр, нийгэм, эдийн засгийн хямралт байдал байгаа учир Монгол хүний үнэ цэнэ унаж доройтлоо. Гэтэл Монголчууд бол шударга ёсыг эрхэмлэдэг, эр зоригтой, эх орондоо хайртай ард түмэн байсаар ирсэн учир Ази тивийн цээжинд тусгаар тогтносон улсаа авч үлдсэн ялалтын түүхтэй ихээхэн үнэ цэнэтэй ард түмэн мөн билээ. Ийм сайхан ард түмнийгээ төр засаг нийтэд нь ажил, орлоготой, залуусыг нь боловсролтой болгох, ахмадуудыг нь эрүүл саруул байлгах замаар монгол хүн бүрийн үнэ цэнийг улам нэмэгдүүлэх учиртай. Аль ч улс оронд төр засгаас гуйхаас илүү шаардаж чаддаг, өөртөө үйлчлүүлж чаддаг тэр ард түмэн үнэ цэнэтэй байдаг. Монголчууд шударга, эр зоригтой ард түмэн мөнгэдгээ үзүүлж, төр засаг амласнаа хэрэгжүүлэхийг нэхэн шаардах цаг ирлээ!

Та бид чадна!

Зургаадах хэсэг. Тулгамдсан асуудлыг шийдэж, Амжилтанд хүрэхүй

Нэгэн зүйл. Та бидний Тулгамдсан асуудал бол:

1. Хариуцлагагүй явдал
2. Ажилгүйдэл
3. Ядуурал

4. Шударга бус явдал

МӨН.

Нэгэн зүйл. Та бидний Амжилт бол:

1. Шударга ёс
2. Ажил, орлого
3. Их бүтээн байгуулалт
4. Эв нэгдэл

МӨН.

Нэгэн зүйл. Тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх, Амжилтанд хүрэхийн тулд заавал их хэмжээний нэмэгдэл зардал шаардагдахгүй. Зөв сэтгэл, туршлага, мэдлэг боловсролд тулгуурлан нийтийн эрх ашгийг эрхэмлэн хамтдаа зүтгэвэл өнөөгийн батлагдсан төсвийн хүрээнд Тулгамдсан асуудлуудыг ч шийдэж болно, Амжилтанд ч хүрч болно.

Долоодох хэсэг. Гурван сайханы эзэн болохуй

Нэгэн зүйл. Монгол хүн Монголдоо, улс орныхоо байгалийн баялагт эзэн болно гэдэг бол анхаарлын төвийг одоогийн төр засгийн нэрийг барьж бүхний төвд дархлагдан сууж байгаа албан тушаалтнуудаас ард түмэн рүү шилжүүлж, Монгол хүнийг дархлан хамгаалах шударга тогтолцоог буй болгоно гэсэн үг мөн. Монгол Улсын оршин тогтнож байгаагийн утга учир монголын ард түмний сайн сайхан амьдралыг цогцлоон бүтээхэд оршиж, Монгол хүн, түүний эрх ашиг бүхний төвд тавих болно.

Нэгэн зүйл. Та бид өнгөрснөө хамтдаа туулж ирснээрээ Монголын ард түмэн хэмээн нэрлэгдэнэ. Гэхдээ Монголын ард түмэн хэмээх ариун нэр зөвхөн өнгөрсөн, улирсаны нэр биш. Та бид ирээдүйгээ хамтдаа урлан бүтээнэ, тэгэж баймааж Монголын ард түмэн хэвээр байна, үргэлж байна хэмээн төсөөлж эхэлсэн тэр мөчөөс эхлэн монголчууд гурван сайханы эзэн болно:

Сайхан хувь заяаныхаа эзэн,

Сайхан байгалийн баялагийн эзэн,

Сайхан Монгол Улсын эзэн.

Тийм ээ, та бид энэ бүхний эзэн мөн!

Энэ бүхний эзэн болох ирээдүй маань нэг!

Наймдах хэсэг. Үг ба үйл нэгдэхүй

Нэгэн зүйл. Өнөөдөр Монгол Улсад “Хэлсэн бол хийдэг”, “Бүтээн байгуулагч” хүн ус агаар мэт үгүйлэгдэж байна. Ярьвал үнэнийг хэлдэг, хийвэл буяныг үйлддэг, явбал бүтээхийг зорьдог тийм л хүн хэрэгтэй. Хэлсэндээ хүрдэг, ам ажил хоёр нь нийлдэг Хүн болцгооё, монголчуудаа.

Есдэх хэсэг. Их аян эхлэхүй

Нэгэн зүйл. Та бидний:

1. *Хариуцлагатай төр засагтай болох,*
2. *Шударга ёсыг тогтоох,*
3. *Ажлын байрыг бий болгох,*
4. *Ядуурлыг арилгах,*
5. *Эв нэгдлийг бэхжүүлэх*

гэсэн зорилго бүхий **Их аян эхэллээ.** Энэхүү Их аяны замдаа та бид Монгол Улсынхаа жинхэнэ эзэд болно, байгалийн баялагаа өмчлөнө, Монгол Хүний үнэ цэнэ, үнэлэмж өсөж нэмэгдэнэ, Монгол Улс эрч хүчтэй болно.

Та бидний энэхүү Их аяны зам бол Жаргалын зам мөн!

Монгол Улс мандтугай!

Монголын ард түмэн үүрд мандан бадрах болтугай!

